



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар

A/607.

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 25 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэрт байрлах “Мянган угалзат” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын мэдэлд байгаа дулаан дамжуулах төв-17-н 1 дүгээр хэлхээний 390м ф125 хос дулааны болон 195м ф89 дан цэвэр усны шугам шинээр солих ажилд зориулан 62 790 588 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 62 790 588 /Жаран хоёр сая долоон зуун ерөн мянга таван зуун наян найман/ төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлж, 2021 оны төсөвт тусгаж буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/607 Ch
02 2756